



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгтгэсэн тайлан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2019/1/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3151

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Б.Дарханбат

Утас: 7054-3179

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт




Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	13
3.2	АВЛАГА, ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15



1 Аудитын гэрчилгээ



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ц.МӨНХ-ОД ТАНАА

2019.08.25 № 59
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй тул сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу хуулийн хугацаандаа санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй, хугацаа хоцроосон, санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгэн гаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг



хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй, тайланд тусгагдсан мэдээллүүд илтэд алдаатай, өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тайланд нэгтгэгдсэн аймгийн "Нэгдсэн эмнэлэг"-ийн төсвийн шууд захирагч хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж, Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйн улмаас санхүүгийн тайланд аудит хийгдээгүй тул санхүүгийн тайланд саналт дүгнэлт өгөхөөс татгалзаж, тайланг баталгаажуулаагүй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа санхүүгийн зөрчлийн асуудалтай зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "оршин байх", "хэмжилт", "үнэн зөв байдал", тохиолдсон байх", "иж бүрэн байх", тодруулга ба толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Одод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.05-наас 2019.03.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газар"-ын аудитор Б.Дарханбат хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаа хоцроож, Говьсүмбэр аймаг



дахь "Төрийн аудитын газар"-т 2019.03.21-ний өдрийн 01/165 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн газар" нь "Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль



- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 1 байгууллага аудитад хамрагдаж, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2			1	
	Дүн	2			1	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаадлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Сангийн яамны цахим нэгтгэлийн програм хангамж ашигладаг байна.



Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт "үр нөлөөгүй" гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр "Нийт зардал-ын 2%-иар сонгов.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,205,391.4 мянган төгрөг бөгөөд түүний 2% болох 64,107.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2%-иар тооцсон нь өмнөх аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд



захирагчийн хэмжээнд 32,807.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, эрүүл мэндийн газрын төсвийн шууд захирагчийн тайланд дээрх алдаа зөрчлийг залруулсан байна.

Харин “Нэгдсэн эмнэлэг”-ийн төсвийн шууд захирагч хуулийн хугацаанд санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй, шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй, аудит хийгдээгүй тул санхүүгийн тайланд саналт дүгнэлт өгөхөөс татгалзаж, тайланг баталгаажуулаагүй болно.

Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд 2018 онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийгдэж, албан тушаалын болон ашиглалтын шинжтэй зөрчил илэрч хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.

Эдгээр зөрчлүүд нь Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлсөн болно.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн төсвийн шууд захирагч хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйн улмаас санхүүгийн тайланд аудит хийгдээгүй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудалтай.

Энэ нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Асуудал 2: Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 25,101.7 мянган төгрөгийн авлага, өр төлбөр бүртгэгдсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5-т заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар



Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүйн улмаас салбарын нэгтгэсэн тайланд аудитлагдаагүй тайланг нэгтгэсэн, алдаа, зөрчил материаллаг дүнтэй байгаа тул төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн төсвийн шууд захирагчийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт оруулж, санхүүгийн тайланг нарийвчлан үзэж үнэн зөв тайлан бэлтгэн гаргуулах шаардлагатай гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагааг аудитад хамруулж дүгнэлт гаргуулаагүй тул төсвийн гүйцэтгэлийн тайлбар, тодруулгыг бэлтгэх боломжгүй болсон.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн “Эрүүл мэндийн салбар”-ын төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийн 2 нь хугацаа болоогүй, 46 буюу 31.3 % нь хугацаа хоцорч оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 33.3%-тай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгсөн боловч нэгдсэн эмнэлгийн санхүүгийн програмыг шинэчлэх, авлага өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.



Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн "Эрүүл мэндийн салбар"-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2016 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.



3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Илрүүлэлт

Аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2018 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд аудитад хамруулаагүй. Аудитад шаардлагатай баримт материал, санхүүгийн тайланг гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж

Аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийлгэх, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэн гаргуулах

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан бодогч

Ц.Мөнх-Од
Б.Буяннэмэх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс хариуцлага тооцуулах



3.2 АВЛАГА, ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

Илрүүлэлт

Санхүүгийн тайланд тусгагдсан 25,101.8 мянган төгрөгийн авлага, өр төлбөр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлд нийцээгүй бөгөөд НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5-т заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж

Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан бодогч

Ц.Мөнх-Од
Б.Буяннэмэх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Эрсдэл

Авлага, өр төлбөрийг тооцоо нийлээгүйгээс эзэн хариуцагч нь тодорхой бус болох



4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан